



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААР "ЭРҮҮЛ ЭЛЭГ" ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТАЛЛАА.


2016-03-17-ны өдөр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурал болж дараах 13-н асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд.

1. Давсны хэрэглээг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, /"Эрүүл элэг" дэд хөтөлбөр батлах тухай/
2. 2016 оны төсөвт, өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэх
3. Ой тэмдэглэх тухай/Номын сан, ахлах 1-р сургууль/
4. Статистикийн салбарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн
5. Худалдан авах ажиллагааны 2015 оны тайлан, Сумдын худалдан авах ажиллагааг үнэлэх журмын хэрэгжилт
6. Увс аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө батлах тухай
7. Ахлах сургуулийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай
8. Архи, согтууруулах ундаа түүгээр үйлчлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
9. Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын 2015 оны тайлан, үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай
10. Увс нуурын гэр баазын менежментийн гэрээний биелэлт
11. Төрийн байгууллагын удирдлага мэдээллийн цогц системийн ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай
12. ОНӨмчийн асуудал
13. Шагналд тодорхойлох тухай



Олон улсын Улаан загалмайн байгууллагын эрсдэлийн менежмент хариуцсан төлөөлөгчийг хүлээн авч уулзлаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ч.Чимэд, Олон улсын Улаан загалмайн байгууллагын эрсдэлийн менежмент хариуцсан төлөөлөгч Бактиар Мамбетов, МУЗН-ийн Олон улсын Улаан загалмайн байгууллагын ажилтан Энхжин нарыг хүлээн авч зудын гамигийг бууруулах чиглэлээр олон улсын Улаан загалмайн байгууллагаас үзүүлсэн тусламжийн үр дүн, зудын гамигийн үр дүнд бий болсон эрсдэлийг арилгах талаар цаашид



хамтран ажиллах чиглэлээр санал солилцлоо. Мөн Увс аймгийн "Улаан загалмайн хороо" нь аймгийн өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдал хүндэрэнтэй холбогдуулан 19 суманд судалгаа явуулсны үр дүнд Тариалан, Сагил, Давст, Малчин, Хяргас, Баруунтуруун, Цагаанхайрхан, Өндөрхангай, Өлгий, Наранбулаг сумуудад ОУУЗ-н шалгуур үзүүлэлтэн дээр тулгуурлан тус бүр 24-н малчин өрх нийт 240-н малчин өрхүүдэд тусламжийг үзүүллээ. Нэг өрхөд 64000₮ дансаар, гурил 25кг, цагаан будаа 10кг, сахар 2кг, давс, ургамлын тос, цай, малын хашианы дулаалгын хучлага 16 метр зэрэг нийт 46 сая төгрөгийн тусламж олголоо. Аймгийн хэмжээнд зарласан "Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгнийхээ төлөө" аяны хүрээнд цугларсан 7,6 сая төгрөгийн эд материалыг 8-н суманд хувиарлан хүргүүлээ.



МҮӨҮЕИЙН 100 БУУДАЛТ ДААМЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ТАМИРЧИД БЭЛТГЭЛЭЭ ХАНГААД БАЙНА.

100 буудалт даамын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 30-нд Улаанбаатар хотноо болох билээ. Манай аймгаас өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд "Гарьд мастер" даамын клубийн 20 гаруй тамирчид оролцохоор бэлтгэлээ хангаад байгаатай аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд танилцаж,



хүүхдүүдтэй ярилцан тэмцээнд нь амжилт хүслээ. Ж.Цэгмэд багштай "Гарьд мастер" даамын клуб нь сүүлийн 4 жил дарааллан багаараа өсвөрийн даамын улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний 3-н байранд шалгарч байгаа ба сүүлийн 3 жил дарааллан бага насны ангиллын бяцхан тамирчид нь 1-р байранд байранд шалгарсан амжилттай оролцож иржээ. Тус клубын тамирчид нь улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцохоос гадна Азийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай оролцон 1,2,3-р байранд тус тус орж байсан байна. Тухайлбал 5-7 насны ангилалд Г. Туул нь МУӨУеийн аварга, Ази тивийн алт, мөнгө, хүрэл медальтай, Ц.Отгонцэцэг МУӨУеийн аварга шалгаруулах тэмцээнээс алт, хүрэл хүртсэн зэрэг өндөр амжилт үзүүлж иржээ.

Хоёр улсын хамтарсан "Я люблю русский язык" тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.

ОХУ, Монгол улсын дипломат харилцаа тогтоосны 95 жилийн ой энэ жил тохиож байгаа билээ. Энэ хүрээнд 2016 оны 03-р сарын 29-31-ний өдрүүдэд ОХУ-ын Тува улсын Дээд Хурлын /Парламентын/ төлөөлөгчид Улаангом хотноо ажиллаа.

Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ОХУ-ын Тува улсын Дээд хурлын /Парламент/ орлогч дарга, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Самоilenko Ирина Петровна, Тува улсын Дээд хурлын нийгмийн бодлогын байнгын хорооны орлогч дарга Монгуш Уляяна Байыр-ооловна, Тувагийн улсын их сургуулийн Тува хэлний хэлзүйн нийгмийн хэл судлалын танхимын докторант Куулар Елена Мандан-ооловна, Тува улсын Дээд хурлын нийгмийн бодлогын байнгын хорооны зөвлөх Грачева Ольга Витальевна, Монгуш Айдан Сергеевна болон бусад хүмүүс ирсэн байна.



Төлөөлөгчдийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ч.Чимэд, аймгийн ИТХ-ын ХХНАХариуцсан хорооны дарга Д.Наранцэцэг, орлогч дарга Т.Нямсамбуу, ИТХ-ын ажлын албаны дарга Х.Төртөгтох, Улаангом сумын ИТХ-ын дарга Б.Жавхлантөгс нар хүлээн авч уулзсан бөгөөд ОХУ-ын Тува улсын Парламент ба Увс аймгийн ИТХ-ын хамтын ажиллагааны хүрээнд явуулах орос хэлний "Я люблю русский язык" уралдааныг хамтран зохион байгууллаа.



**84-Н ИРГЭН ШИНЭХЭН БАЙРНЫ ТҮЛХҮҮРЭЭ
ГАРДАН АВЛАА.**

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Төрийн түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд БХБЯ-ны сайдын 2016.02.23-ны өдрийн 28-р тушаалаар батлагдсан “Иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын дагуу зорилтот долоон бүлгийн



иргэдийг энэ сарын нэгнээс эхлэн түрээсийн орон сууцанд хамруулж байгаа билээ.

Энэ сарын 21-25-ны өдрүүдэд “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын Тэргүүн дэд захирал Д.Алтанхуяг тэргүүтэй ажлын хэсэг манай аймагт ажиллаа. 400 гаруй иргэн өргөдөл хүсэлтээ ирүүлснийг судлан шалгуур үзүүлэлт хангасан зорилтот долоон бүлгийн 84 өрхөд байрны түлхүүр гардуулах үйл ажиллагаа “Ойрад” ХДТ-т ёслол төгөлдөр болж Аймгийн удирдлагууд, ТОСК-ын тэргүүн дэд захирал нар зорилтот долоон бүлгээс нэг, нэг өрхийг төлөөлөл болгон алд цэнхэр хадагны хамт байрны түлхүүрийг нь гардуулан өглөө.

САГИЛ СУМ:

Увс аймгийн Сагил сумын 2016 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтын хүрээнд “Хүүхдийн шүдний эмгэг, түүнээс урьдчилан сэргийлэх нь” арга хэмжээг тус сумын эрүүл мэндийн төв нь аймгийн эрүүл мэндийн төв, Ц.Дагвасүрэн захиралтай шүдний эмнэлэгийн хамт олонтой хамтран 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаатайгаар зохион байгуулж байна. Хүүхдийн шүдний цооролт, өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх бат бөх тогтоцтой “UltraSeal” сийлантаар эмчилдэг сайн чанартай юм байна. Энэ арга хэмжээг зохион байгуулахад сумын удирдлагууд, сургуулийн захиргаа нь байр, хоол, хүүхдүүдийг хамруулах гэх зэргээр хамтран ажиллалаа.



Тус сумын ИТХ, ОХУ-ын Тува улсын Өвөрхошууны хурлын байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу Монгол ОХУ улсуудын хооронд дипломат харилцаа тогтоосны 95 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан Увс аймгийн Сагил сумын дунд сургууль, Улаангом сумын 3-р арван жилийн сургууль, ОХУ-ын Тува улсын Өвөрхошууны Хандгайт тосгоны сургуулиуд хамтарч урлаг спортын /бөхийн барилдаан, хүүхдийн концерт/, орос монгол хэлний хичээлийн заах арга зүйгээр хамтран өрсөлдөө. Цаашид ОХУ-ын Тува улсын Өвөрхошууны Хандгайт тосгоны боловсролын салбартай, хамтран ажиллах, хоёр талын харилцааг хөгжүүлэх талаар санал солилцоо.

ЗҮҮНГОВЬ СУМ:

Худалдаа, худалдааны үйлчилгээ, хоол үйлдвэрлэл эрхэлдэг цэг салбарт үзлэг шалгалт явуулах ажлын хэсгийг ЗДТГ-ын байцаагч нар цагдаагийн ажилтануудын бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж 11 нь цэгт үзлэг хийсэн ба дэлгүүр хүнсний мухлагуудын эмх цэгц муу, цэвэрлэгээ хангалтгүй, ажилтануудын нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ бүрэн төлөөгүй зориулалтын хувцас хэрэглэдэггүй, байр тоног төхөөрөмжийг халдваргүйжүүлэлт муу, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал хадгалалтын нөхцөл шаардлага хангаагүй зэрэг гарсан зөрчлийг арилгах талаар үүрэг даалгавар өгөн ажиллалаа. Сургуулийн гал тогоонд уурын яндан нэмж хийх, пивор шанага хэрэглэхгүй байх, Эрүүл мэндийн төвийн гал тогоонд дээж хадгалах хөргөгч байхгүй тогооч нар эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй зэрэг дутагдал гарсаныг арилгуулах талаар үүрэг өглөө.

ӨЛГИЙ СУМ:

Манай сум нь Аймагтаа зудад нэрвэгдсэн сумын тоонд орж байгаа тул Аймгийн Улаан загалмай нийгэмлэг болон Онцгой байдлын газраас 24 айлын судалгааг аван тус бүрд нь 192,000 мянган төгрөгний мөнгө, хүнсний зүйлийн туслацгаа үзүүлээ.



Тусламжийг Аймгийн УЗ н хорооны дарга Дуламсүрэн, Онцгой байдлын газрын дэд дарга Өлзийт нар ирж сумын УЗ н хорооны дарга,

Х.Шагдаржав, нарийн бичгийн дарга Ч.Оюунтуул Сумын удирдлагуудын хамт сумын ЗДТГ-ын үүдэнд гардуулан өглөө.

МАЛЧИН СУМ:

Хөдөөгийн гурван багт ЗДТГ-аас байцаагч нар,хүн,малын эмч нарыг оролцуулсан ажлын хэсэг гарган тусгай удирдамжийн дагуу хаваржилтын явцтай танилцаж малын хоргодол судлах,өвс тэжээл нэн шаардлагатай айл өрхийг тогтоох,хүн ,малын эмч нарын үйлчилгээг газар дээр нь хүргэх ажлыг 5 хоногийн хугацаанд хийлээ.Монгол улсын Засгийн газрын болон Азийн хөгжлийн банк,НУБ,МУЗН-ийн хандив тусламж хуваарьлах, хүргэх ажлыг тухай бүр хийж байна. Одоогийн байдлаар сумын дүнгээр 4900 гаруй толгой малын хоргодолтой байна. 2015 оны жилийн эцсээр актлагдсан эргэлтийн хөрөнгийг сумын Өмч хамгаалах зөвлөл байгууллага бүр дээр үзэж устгах ажил хийлээ.

ХОВД СУМ:

-Сонгуулийн сурталчилгааны материал байрлуулах газар тогтоох тухай.
- 2015 оны орон нутгийн өмчийн тооллогын дүн, хөрөнгө актлах тухай.
- Алдарт эх одонгоор шагнуулах тухай.
- бусад асуудлууд зэрэг 4 асуудал хэлэлцэж 17 заалт бүхий 6 тогтоол гаргалаа.
ИТХ-ын нарийн бичгийн дарга Ачит, Шивэр багт ажиллаж хаваржилт мал төллөлтийн байдалтай танилцаж УИХ-ын сонгуулийн санал хураах хэсгийн төв, иргэдийн бичиг баримтын бүрдэл, сонгуулийн хуулийн тухай 112 өрхөд мэдээлэл түгээж ажиллаа. Ачит, Ховд, Шивэр багийн ИНХ-д хуралд оролцож ИТХ - аас гарсан шийдвэрүүдийг танилцуулж, Сонгуулийн тухай хуулиар иргэдэд мэдээлэл өглөө.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал